



2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН





ЗАСАГЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2018 оны 12-р сарын 31-ний байдлаар компанийн гаргасан 10 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 15,734,200 ш энгийн хувьцааг 244 хувьцаа эзэмшигчид эзэмшиж байна.

2018 оны 2 –р сарын 20 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бүс хурал

- Компанийн хувьцааг 100 хуваах, нэрлэсэн үнийг тогтоох, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг зөвтгөх, компанийн дүрэмд өөрчлөлт оруулах
- Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинээр томилох
- Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл батлах асуудлыг хэлэлцэв

2018 оны 04 -р сарын 02 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал

- Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлт
- Нэмж хувьцаа гаргах тухай, хувьцаа нэмж гаргах төсөл
- Нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авахыг эрхийг эдлүүлэх эсэх
- ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох
- Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг шийдвэрлэв.

ТУЗ, хороодын үйл ажиллагаа

- ТУЗ-ийн шинэ бүрэлдэхүүн дотоод зохион байгуулалтаа хэлэлцэн Аудитын хороо, Цалин урамшууллын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Бодлого төлөвлөлтийн хороодыг байгуулав.
- Компанийн ТУЗ болон дэргэдэх хороод нь тогтмол хуралдаж, эрх үүргийнхээ хүрээнд шаардлагатай тогтоол шийдвэрүүдийг гаргаж ирлээ.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



4405600 ш хувьцааг 3.7 тэрбум төгрөгөөр анхдагч зах зээлд арилжлаа

Хувьцаа хуваах болон нэмж гаргах бэлтгэл ажлыг үе шаттайгаар хангаж, Монголын Хөрөнгийн бирж болон Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрлийн дагуу хувьцаа нэмж гаргах ажлыг 2018 оны 09 дүгээр сарын 12-нд амжилттай хэрэгжүүлсэн.

Хувьцаа

- МХБ-ийн 3-р ангиллаас 2-р ангилалд дэвшсэн
- ТОП20 индексийг бүрдүүлэгч хувьцааны жагсаалтанд оров.
- 2018 онд хувьцааны ханш 28 дахин өссөн


Компани

- Олон улсын чанарын удирдлагын тогтолцоо ISO9001:2015 стандартыг нэвтрүүлэв
- Өмнөх оноос борлуулалт **3** дахин, үйлдвэрлэл **4** дахин өсөв
- Цэвэр ашиг өмнөх оноос 8.5 дахин өслөө



БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХҮНИЙ НӨӨЦ

- Компани 2018 онд нийт 69 ажиллагсадтай боллоо. Ажиллагсадынхаа нийгмийн хамгаалал, цалин хөлсний бодлого, цалин урамшууллын системийг шинэчиллээ
- Дундаж цалин өмнөх оноос 60% өслөө





ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ

Тариалалт ба ургац


Таримлын төрөл	Тариалалт /га/	Ургац /тонн/
Улаанбуудай	3946	5975
Арвай	27	3
Овьёос	21	55
Рапс	420	29
Бусад	25	38
Нийт	5975	6050

- Тариалангийн талбайн 3500 орчим га-д хөрсний шинжилгээг хийлгэв.
- Сэлгээний ургамлыг нэмэгдүүлэх зорилгоор түршилтанд вандуй, гурвалжин будаа тарив.
- Нарт Шүүн ХХК-тай хамтран 1 га талбайд 16 сортын улаанбуудайн үрийг 3 давталттайгаар сорт сорилтоор тариалсан түршилтыг хийв.

ГУРИЛ, ТЭЖЭЭЛИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ

- Гурилын үйлдвэр 2018 онд нийт 8.7 мян тонн буудай тээрэмдэж, 7.0 мян тн гурил, 1.7 мян тн дайвар бүтээгдэхүүн үйлдвэрлэв.
- Үтрэмд 2018 оны ургацаас 12.1 мян тн буудай хүлээн авав.
- Борлуулалт маркетингийн системийг шинэчлэх, өргөжүүлэх ажлыг төлөвлөж хэрэгжүүлэв.
- Борлуулалтын орлого **3** дахин, харилцагчдын тоо **2** дахин өссөн байна

Гурилын үйлдвэрлэл





САНХҮҮГИЙН ТАЙЛАН

ОРЛОГО, ҮР ДҮН

	2016	2017	2018
САНХҮҮГИЙН ОРЛОГО, сая төг			
Үр тариа, тэжээлийн борлуулалт	620	404	1,526
Гурилын борлуулалт	2,289	2,000	6,083
Бусад	349	57	
НИЙТ САНХҮҮГИЙН ОРЛОГО	3,258	2,461	7,609
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	2,347	1,997	6,551
НИЙТ АШИГ	911	464	1,059
Боловсон хүчний холбогдолтой зардал	96	167	195
Ерөнхий удирдлагын бусад зардал	148	197	508
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ЗАРДАЛ	244	364	703
ЕРӨНХИЙ ҮЙЛ АЖ-НЫ ЦЭВЭР АШИГ	666	100	356
Санхүүгийн зардал	480	410	252
Ердийн бус орлого зардал	(270)	346	235
ТАТВАРЫН ӨМНӨХ ОРЛОГО	(84)	37	339
Татварын зардал	1	0	24
ТУХАЙН ҮЕИЙН ЦЭВЭР АШИГ/АЛДАГДАЛ	(85)	37	315



САНХҮҮГИЙН ТАЙЛАН

ХӨРӨНГӨ ӨР ТӨЛБӨРИЙН БАЙДАЛ

	2015	2016	2017	2018
Бэлэн Мөнгө	4	50	506	1261
Авлага	594	441	1443	1477
Бараа Материал	794	1426	1119	3964
Бусад эргэлтийн хөрөнгө	135	174	152	611
Нийт эргэлтийн хөрөнгө	1527	2091	3221	7313
Газар	463	463	3379	3379
Барилга	1181	1181	5236	6512
Тоног төхөөрөмж, машин	5225	5209	13054	13922
Тавилга, эд хогшил	41	46	41	77
Нийт үндсэн хөрөнгө ба газар	6910	6899	21710	23890
Элэгдэл	2006	2514	10426	12315
Цэвэр үндсэн хөрөнгө	4904	4385	11284	11575
Барааны тэмдэг ба хөрөнгө оруулалт	3	4	188	125
НИЙТ ХӨРӨНГӨ	6434	6480	14693	19013
Богино хугацаат зээл	1,863	1,994	3,205	5,025
Дансны өглөг	935	598	697	877
Бусад богино хугацаат өглөг	25	116	141	136
Нийт богино хугацаат өглөг	2823	2708	4043	6038
Урт хугацаат зээл	191	541	0	0
Бусад урт хугацаат өглөг	202	202	202	202
Нийт урт хугацаат өглөг	393	743	202	202
Нийт өр төлбөр	3217	3451	4244	6240
Хувьцаа	102	102	102	157
Нэмж төлөгдсөн капитал	0	0	0	3356
Хөрөнгийн дахин үнэлгээ	0	0	7383	5993
Хуримтлагдсан Ашиг	3115	2926	2963	3267
Нийт өөрийн хөрөнгө	3218	3029	10449	12773
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГ	6434	6480	14693	19013

ХААН банкны зээлийн үлдэгдэл 1.2 тэрбум, ХХААХҮЯ-ны МХС-аас авсан зээлийн үлдэгдэл 3.8 тэрбум төгрөг байна.



БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Хувьчлагдснаас хойш 20 жил болж байгаа түүхт жилийн хүрээнд ахмад үеэ алдаршуулах, залуу үеэ урамшуулах хөтөлбөрүүд, мөн компанийн үйл ажиллагааг таниулахад чиглүүлсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулав.
- Хөвсгөл нутгаас төрж гарсан хөгжмийн зохиолчидод хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ, тоглолтыг ивээн тэтгэж зохион байгууллаа.

